



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



Empowered lives
Resilient nations

“БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТ БҮХИЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР
НУТГИЙН СҮЛЖЭЭ” МОН/13/303 ТӨСӨЛ

“ХАВТГАР”

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР

ОЙТ ХЭЭРИЙН БҮСЭД НУТГИЙН
ИРГЭДЭД ТҮШИГЛЭСЭН БАЙГАЛИЙН
НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЗАГВАР




“ХАВТГАР”-ЫН ОНХГ

ОЙТ ХЭЭРИЙН БҮСЭД НУТГИЙН ИРГЭДЭД ТҮШИГЛЭСЭН
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЗАГВАР

ОНХГ-т авсан зорилго:

- Байгалийн нөөцийг тогтвортой ашиглах, зэрлэг ан амьтны өсөж үржих таатай орчныг бүрдүүлснээр ан агнуурын менежмент, аялал жуулчлал хөгжүүлэх замаар сумын нийгэм, эдийн засаг, нутгийн иргэдийн амьжиргаанд бодитой хувь нэмэр оруулах зорилгоор Хан Хэнтийн дархан цаазат газрын хил залгаа, Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг “Хавтгар” орчмын **104,936 га** газрыг сумын ИТХ-ын 2003 оны 2-р сарын 12-ны өдрийн 03 дугаар тогтоолоор орон нутгийн тусгай хамгаалалтад авсан.
- Батширээт сумын ИТХ-ын 2017 оны 10-р сард гаргасан тогтоолоор Хавтгарын хилийн цэсийг шинэчлэн тогтоож хуш болон нарсан ойн нөөц газрыг нэмэгдүүлэх, нөхөн сэргээх зорилгоор орон нутгийн хамгаалалтад байх хугацааг **20 жилээр** сунгасан.



ОНХГ-ын түлхүүр зүйлүүд

ХӨХТӨН		
Халиун буга	<i>Cervus elaphus</i>	Red deer
Молцог хандгай	<i>Alces alces</i>	Moose
Баданга хүдэр	<i>Moschus moschiferus</i>	Musk deer
Бор гөрөөс	<i>Capreolus pygargus</i>	Roe deer
Зэрлэг гахай	<i>Sus scrofa</i>	Wild boar
Монгол тарвага	<i>Marmota sibirica</i>	Mongolian marmot


ШУВУУ		
Үлэг харцага	<i>Accipiter gentilis</i>	Nothern goshawk
Хар хур	<i>Lyrurus tetrix</i>	Black grouse
Алаг тоншуур	<i>Dendrocopos major</i>	Great spotted woodpecker
Цэнхэр цанцаахай	<i>Cyanopica cyana</i>	Azure-winged magpie
Бидэрт самарчаазгай	<i>Nucifraga caryocatactes</i>	Spotted nutcracker
Их хөхбүх	<i>Parus major</i>	Great tit

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ГАРСАН АМЖИЛТ, ҮР ДҮН:



Нутгийн иргэдэд түшиглэсэн менежментийн бүтэц, зохион байгуулалт бий болсон:

“Хавтгар” ОНТХГ-ын менежментийн бүтэц



- Хавтгар ОНТХГ-ын менежментийн бүтэц шинэчлэн зохион байгуулагдаж, менежментэд оролцогч талуудын хүлээх эрх үүргийг хуулийн хүрээнд шинэчлэн тодорхойлж, Менежментийн зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнд 70% нь нөхөрлөлийн гишүүд, 30% нь сумын удирдлага орсноор асуудлыг хамтдаа шийдвэрлэх боломж бүрдсэн.
- Тус ОНТХГ-ын хамгаалалтын менежментийг 2014 оноос хойш “Хавтгарын хөгжил” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар (ОНӨААТҮГ) (цаашид менежментийг хариуцагч гэх) гэрээгээр хариуцан хэрэгжүүлж байна.



- Тус ОНХГ-ын хилийн орчимд амьдардаг нийт 88 өрхийн 180 гишүүнтэй 6-н ойн нөхөрлөл менежментийг хариуцагчтай хамтран хамгаалалтын үйл ажиллагаа хэрэгжүүлснээр Хавтгар ОНХГ, улмаар Хан Хэнтийн улсын ТХГН-т үзүүлэх дарамтыг бууруулж ойн нөөц, ан амьтны өсч үржих таатай орчин бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.
- Дээрх 6 нөхөрлөлд нийт 8 Идэвхтэн байгаль хамгаалагч хариуцан хамгаалж буй газар нутагтаа зэрлэг амьтны мониторинг, эргүүл хяналтийг хийж байна.
- Биологийн олон янз байдлыг цогцоор нь хамгаалах, эргүүл хяналт, зэрлэг ан амьтдын мониторингийг арга зүйн дагуу гүйцэтгэх, ойн түймэр, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох зэрэг арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх зорилгоор менежментийг хариуцагч хуулийн этгээд, Батширээт сумын Засаг дарга, Хан Хэнтийн хамгаалалтын захиргаа хооронд Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан ажиллаж байна.




ОНТХГ-ын менежментийн үр ашигт байдал нэмэгдсэн:

- Төсөл хэрэгжих хугацаанд Хавтгар ОНХГ-ын менежментийн үр ашигт байдал 60%-р өсч оноо нь 2013 онтой харьцуулахад 26-аас 65-д хүрсэн ба 2017 оны сүүлчээр менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт 70%-тай байна.



Түлхүүр зүйлийн тоо толгой өссөн:



Эх үүсвэр: Хан Хэнтийн ДЦГ-ын ХЗ-ны мониторингийн тайлан



Боловсруулан хэрэгжүүлж буй баримт бичгүүд:

- Хавтгар ОНХГ-ын дунд хугацааны стратеги (2015-2020)
- ОНХГ-ын менежментийн төлөвлөгөө (2015-2020)
- ОНХГ-ын Бизнес төлөвлөгөө (2015-2018) тус тус боловсруулагдан сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар батлагдан хэрэгжиж байна.
- Хавтгар ОНХГ-ын менежментийг хариуцагчийн үйл ажиллагааг дэмжих дүрэм, журам шинээр болон шинэчлэгдэн боловсруулагдаж, сумын ИТХ-аар хэлэлцүүлэн баталсан. Үүнд:
 - Менежментийг хариуцагч хуулийн этгээдийн дүрэм, гишүүнчлэлийн журам, удирдах болон хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм
 - ОНХГ-ын хилийн цэсийг шинэчлэн тогтоох, агнуурын бүс нутгийн менежментийг харицуулах, менежментийн төлөвлөгөө батлах, ОНӨААТҮГ-т төрийн зарим чиг үүргийг хариуцуулах, ойн арчилгаа, цэвэрлгээ, мод бэлтгэлийн ажилд Хавтгарын нөхөрлөлүүдийг оролцуулахыг дэмжсэн тогтоол шийдвэрүүд



Менежментэд оролцогч талуудын идэвх санаачилга эрс дээшилсэн:

- Нөхөрлөлүүдийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор нийт **46,1 сая төгрөгийн 7 жижиг төслийг** хэрэгжүүлсэн. Үүнээс 17,9 сая төгрөгийг төслөөс, 28,2 сая төгрөг нөхөрлөлүүд өөрсдийн хөдөлмөр болон бусад зардлаар гаргасан. Согоот, Мон-Эг нөхөрлөлүүд жижиг төслийн хүрээнд хүнсний ногоо тариалах, даршлах чиглэлээр үйл ажиллагаагаа өргөжүүлж орлого нь **20-оос 38%-р**, нэмэгдэж, Цэгээн нөхөрлөл буриад талх, нарийн боовны төрлөө нэмэгдүүлж, сав баглаа боодлоо сайжруулснаар орлого нь **122%** өссөн.
- Байгаль хамгаалагчдын тогтвортой ажиллах нөхцлийг хангах зорилгоор Баянгол, Эгийн постын байруудыг засварлаж тохижуулах ажлыг сумдын ЗДТГ болон “Хавтгарын хөгжил” ОНӨААТҮГ-тай хамтран хийсэн.
- Хавтгар ОНХГ-ын хамгаалалтын менежментэд оролцогч талууд болох сумын төр захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтнууд, байгаль хамгаалагч, идэвхтэн байгаль хамгаалагч, нөхөрлөлийн гишүүдэд зориулсан сургалт, нөхөрлөл хөгжлийн наадам, туршлага судлах аялал зэрэг арга хэмжээг шат дараатай зохион байгуулж давхардсан тоогоор нийт **1000** орчим хүн хамрагдсан.
- Менежментийг хариуцагч байгууллагад 4,4 сая төгрөг, Батширээт сумын ЗДТГ-т 2,5 сая төгрөг, аймгийн Онцгой Байдлын Газарт 1,8 сая төг, Хан Хэнтийн ДЦГ-ын хамгаалалтын захиргаанд 3,3 сая төгрөг, нөхөрлөлүүдэд 4,0 сая төгрөг - нийт **16 сая төгрөгийн** үнэ бүхий техник хэрэгсэл, мэдээллийн тоног төхөөрөмжийг тус тус олгосноор Хавтгар ОНХГ-ын хамгаалалтын менежментэд оролцогч талуудын чадавхи бэхжиж, ажиллах нөхцөл сайжирсан.





Хавтгар ОНХГ-т төсөл хэрэгжүүлснээр гарсан ТЭРГҮҮН ТУРШЛАГА


- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд ОНХГ-ын менежментийг “Хавтгарын хөгжил” ОНӨААТҮГ-т гэрээгээр хариуцуулснаар ОНХГ-ын тогтвортой санхүүжилтийг бүрдүүлэх хүрээнд бизнесийн үйл ажиллагаа эрхлэх боломжийг олгож байна.
- Хамгаалалтын менежментэд Хан Хэнтийн хамгаалалтын захиргааг татаж оролцуулсан нь идэвхтэн байгаль хамгаалагч нарын мониторинг, судалгаа, эргүүл хяналт хийх чадавхийг бэхжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, менежментийг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэж байна.
- Аймгийн БОАЖГ-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажилласнаар сумын түвшний шийдвэр гаргагч нарт байгаль орчны хууль эрх зүйн мэдлэг олгох сургалт, хэлэлцүүлгийг үе шаттай хийсэн. Үүний үр дүнд менежментийг хариуцагчийн үйл ажиллагааг дэмжих, Хавтгар ОНХГ-т байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг эргэн зарцуулах, нөхөрлөлүүдийг дэмжих чиглэлээр сумын ИТХ-ын тогтоол, шийдвэрүүд батлагдсан. Мөн аймаг, сумын төсвөөс Хавтгарын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулах төсөвийг оновчтой хувиарлах эхлэл тавигдсан.
- ОНХГ-ын Менежментийн зөвлөлд сумын ИТХ, ЗДТГ, менежментийг хариуцагч, бүх нөхөрлөлийн төлөөлөл орсон нь нэг талаас сумын зүгээс байгаль хамгаалах талаар баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээтэй уялдуулах, нөгөө талаас менежментийг хэрэгжүүлэгч нар тулгамдаж буй асуудлаа цаг хугацаанд нь шийдвэрлэх боломж нээгдсэн.






Хавтгар ОНХГ-т төсөл хэрэгжүүлснээр гарсан СУРГАМЖ

1. Менежментийг хариуцагчтай байгуулсан гэрээг дүгнэх, үнэлэх механизм тодорхой байх шаардлагатай. Үүнд:
 - a. гэрээг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг (ОНХГ-ын үнэт зүйлс, экосистем, биологийн олон янз байдлын төлөв байдлыг суурь нөхцлөөс дордуулахгүй байх, сайжруулах, биологийн төрөл зүйлд учирч байгаа аюул заналыг бууруулах арга хэмжээг тодорхойлох, г.м.) тогтоож гэрээний салшгүй хэсгээр авч үзэх;
 - b. менежментийг хариуцагчийн хэнд, хэзээ тайлагнах талаар гэрээнд тодорхой зааж өгөх;
 - c. гэрээний хэрэгжилтийг жил бүр дүгнэж, гэрээг сунгах, цуцлах талаар албан ёсны шийдвэр гаргаж менежментийг хариуцагчид мэдэгддэг байх
2. ОНХГ-ын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, төлөвлөгөөнд тодорхойлсон зорилт, шалгуур үзүүлэлтүүдийг хангаж буй эсэхэд хамтын оролцооны аргаар 2 жилд нэг удаа үнэлгээ хийх (“Хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашигт байдлын үнэлгээ” МОН-METT аргагүй)
3. Хавтгар ОНХГ-ын байгалийн нөөцийн ашиглалтад хяналт бүртгэлийг нэвтрүүлж Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Засгийн газрын 2014 оны 43-р тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах” журмын хэрэгжилтийг хангах
4. Нутгийн иргэдэд түшиглэсэн агнуурын менежментийг тусгай сонирхлын аялал жуулчлалтай хослуулан хөгжүүлэх.



“ХАВТГАР” ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР



НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр - www.undp.mn

Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар - www.mpa.gov.mn